



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 1.2, 4.1, 4.2 дахь заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн жинхэнэ албан хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Багийн ахлагч:

1 Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

1 Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

2 Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга

3 Ц.Түвшинзаяа

Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга

4 Д.Дэлгэрмаа

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Н.Дагиймаа

Хүний нөөцийн мэргэжилтэн

2.Албан хаагчдын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэж, баталгаажуулсан тайланг Даргын зөвлөлд танилцуулахыг үнэлгээний багт даалгасугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132063207